



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

┌ Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд ┐
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Централ секюритиз УЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 300,000,000 /гурван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Централ секюритиз УЦК” ХХК /Д.Баярсайхан/-д үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2020 оны 1 дугаар сарын 29-ны өдрийн
26 дугаар тогтоолын хавсралт



“Централ секюритиз УЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн
хэмжээнд оруулсан өөрчлөлт

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны нэрлэсэн үнэ /₮/	Хувьцааны эхний үлдэгдэл			Өөрчлөлт		Хувьцааны эцсийн үлдэгдэл		
			Тоо ширхэг	Үнийн дүн /₮/	Эзлэх хувь /%/	Хувьцааны тоо	Үнийн дүн /₮/	Тоо ширхэг	Үнийн дүн /₮/	Эзлэх хувь /%/
1	Д.Баярсайхан	1000	100,000	100,000,000	100%	300,000	300,000,000	400,000	400,000,000	100%
	Нийт	1000	100,000	100,000,000	100%	300,000	300,000,000	400,000	400,000,000	100%